

Нэгдүгээр хэсэг. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцана уу.

- Энэхүү хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Монгол хэл, уран зохиол, үндэсний бичгийн нэгдмэл агуулгаас бүрдэнэ.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэгийг сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.

Монгол хэл:

- Эсээг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

Нүүдэлчдийн сэтгэлгээ (эсээ)

2

Хүн төрөлхтний үлэг оршил нь нүүдэл. ...Нүүдэлчдийн оршихуй бол байгаль дэлхий, одон ертөнцтэй зохицон орших оршил. Энэ оршил орчлон ертөнц дээрх өвөг оршил. Амьтан ургамал, уул ус цөм байгаль дэлхий, одон ертөнцтэй зохицон оршихыг эрмэлздэг.

Өвөг оршил нь язгуур сэтгэлгээг бий болгоно. Юмс үзэгдлийг орчлон ертөнц хийгээд бусад юмс үзэгдэлтэй харилцах харилцаанд нь авч үзэж бясалгадаг сэтгэлгээ бол язгуур сэтгэлгээ. Нүүдэлчин монголчууд бол язгуур сэтгэлгээт үндэстэн. Язгуур сэтгэлгээ нь бодотоос* хийсвэр лүү, хийсвэрээс бодот руу орж гарах мэтээр үргэлжийн хөдөлгөөнд байдаг.

Эртний монголчууд орон сууцаа бүтээхдээ гараг эрхсийн түгээмэл хэлбэр болох бөмбөрцөгөн дүрсийг сонгосон нь эдүгээгийн монгол гэр юм. Оршин байх хэлбэрүүдийн дотроос хамгийн бөх бат, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр. Атом цөмийн нар, сар, одон гараг хүртэлх юмс цөм бөмбөрцөг хэлбэртэй.

Тухайн үндэстэн үнэнхүү язгуур сэтгэлгээтэй байж гэмээн л ертөнц дээрх олон хэлбэрүүдийн дотроос бөмбөрцөг хэлбэрийг сонгосон байж таарна. Энд бөх батаас гадна зохицлыг илүү бодсон нь илт.

Хязгаар хярхаггүй олон гараг эрхсийн эрхшээл дунд оршин тогтнох найдвартай хэлбэр бол тэдэнтэй ижилхэн хэлбэртэй орших явдал гэдэг нь маргаангүй.

Эртний монголчуудын эдэлж хэрэглэж байсан сархинаг тоонотой гэр бол эдүгээгийн хатгуур тоонот гэрийг бодвол илүү бөмбөгөр. Тийм гэр өнгөрсөн зууны тавиад оныг хүртэл говийн малчдад мэр сэр байсаар л байсан. Сархинаг тоонот гэр ямар ч догшин салхи, ширүүн бороонд унадаггүйгээр үл барам, хаяаг нь дээш нь сайн шуучихад үерийн ус дайраад өнгөрөхөөс биш аваад явчихдаггүй. Хожимдоо монгол гэрийн унь, тооно хоёр нь саланги болж, тэдгээрийн харьцаа алдагдсанаас конус хэлбэр лүү ойртон шовойж, салхи шуурганд өртөмтгий болсон юм. Хэдийгээр унь, тооно, хана, хаалга, хатавчийн харьцаа өөр болсон хэдий ч монгол гэрийн үндсэн хэлбэр төрх, хийц маяг нь өөрчлөгдөлгүй манай үед хүрч ирсний гол шалтгааныг зөвхөн нүүдэллэн хэрэглэхэд тохиромжтой байснаар тайлбарлавал өрөөсгөл болно. Монголчуудын гурван мянга гаруй жил орон сууцаа үндсээр нь өөрчлөөгүй шалтгааныг сэтгэлгээнээс нь хайх хэрэгтэй. Сууринчдын сэтгэлгээ бол хэрэглээний эрхшээлээр байгалийг өөртөө зохицуулан өөрчлөхийг эрмэлздэг сэтгэлгээ. Нүүдэлчдийн сэтгэлгээ бол байгалийн эрхшээлээр хэрэглээгээ хязгаарлан, байгальд өөрийгөө зохицуулан өөрчлөхийг эрмэлздэг сэтгэлгээ. Энэ бол язгуур сэтгэлгээний төрх.

Өрөөс язгуур сэтгэлгээ бол байгаль цаг агаарын эрс тэс өөрчлөлтгүй үед агуулга хэлбэрийн үл хувьслыг эрхэмлэдэг. Нүүдэлчдийн сэтгэлгээний үндэс нь ийм учраас тэд хэлбэрийг ч, агуулгыг ч өөрчлөхийг төдийлөн хүсдэггүй. Нүүдэлчдийн ойлголтоор, хэлбэр бол байгаль орчинтой зохицох зайлшгүй нөхцөл, агуулга бол орчлон ертөнцөд өнө удаан оршихын үндэс. Эл учир алив бүхний үнэ цэн, чанар чансааны дээд үнэлэмж бол үзэмж бус хүч тэнхээ, оюун билиг. Байгаль дэлхийтэйгээ зохицон оршиход хүч тэнхээ, ухаан билгээс өөр эрхэм нь үгүй.

Дарма. Батбаяр

бодотоос* - Зохиогчийн бичлэгийн онцлог хадгалсан үг. (бодит гэсэн утгатай)

1. Эсээнд буй үг ямар утга илэрхийлж байна вэ? Тайлбартай нь харгалзуулаад тохирох хувилбарыг сонгоорой.

Үг	Харгалзаа	Үгийн тайлбар
1. оршихуй	☐	☐ а. уг, эх үүсэл, тэргүүн
2. язгуур	☐	☐ б. амьдрах, аж төрөх үндэс
3. хатавч	☐	☐ в. гэрийн хаалга, хана хоёрын уулзвар
4. шуух	☐	☐ г. олон цоорхой нүх сүв болсон нь
5. сархинаг	☐	☐ д. дээш болгох, сөхөх, өргөх

- A. 1b, 2a, 3c, 4e, 5d
 B. 1b, 2a, 3d, 4c, 5e
 C. 1d, 2e, 3b, 4a, 5c
 D. 1d, 2b, 3a, 4e, 5c
 E. 1b, 2e, 3c, 4a, 5d



2. Эсээний хөтөч санаа аль нь вэ?
- Амьтан ургамал, уул ус цөм байгаль дэлхий, одот ертөнцтэй зохицон оршихыг эрмэлздэг.
 - Атом цөмийн нар, сар, одон гараг хүртэлх юмс цөм бөмбөрцөг хэлбэртэй.
 - Оршин байх хэлбэрүүдийн дотроос хамгийн бөх бат, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр.
 - Нүүдэлчдийн оршихуй бол байгаль дэлхий, одон ертөнцтэй зохицон орших оршил.
 - Язгуур сэтгэлгээ нь бодотоос хийсвэр лүү, хийсвэрээс бодот руу орж гарах мэтээр үргэлжийн хөдөлгөөнд байдаг.
3. “Сархинаг тоонот гэр ямар ч догшин салхи, ширүүн бороонд унадаггүй.” гэсэн хэсгийн толгой өгүүлбэр аль нь вэ?
- Монголчуудын гурван мянга гаруй жил орон сууцаа үндсээр нь өөрчлөөгүй шалтгааныг сэтгэлгээнээс нь хайх хэрэгтэй.
 - Юмс үзэгдлийг орчлон ертөнц хийгээд бусад юмс үзэгдэлтэй харилцах харилцаанд нь авч үзэж бясалгадаг сэтгэлгээ бол язгуур сэтгэлгээ.
 - Тийм гэр өнгөрсөн зууны тавиад оныг хүртэл говийн малчдад мэр сэр байсаар л байсан.
 - Хожимдоо монгол гэрийн унь, тооно хоёр нь саланги болж, тэдгээрийн харьцаа алдагдсанаас конус хэлбэр лүү ойртон шовойж, салхи шуурганд өртөмтгий болсон юм.
 - Хязгаар хярхаггүй олон гараг эрхсийн эрхшээл дунд оршин тогтнох найдвартай хэлбэр бол тэдэнтэй ижилхэн хэлбэртэй орших явдал гэдэг нь маргаангүй.
4. Эсээний дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлсныг олно уу.
- Гараг эрхсээс санаа авч гэр бүтээсэн тухай
 - Монгол гэрийн төрөл зүйл, онцлогийн тухай
 - Орчлон ертөнцтэй дасан зохицож амьдрах тухай
 - Монгол гэр бөмбөрцөг хэлбэртэй байдаг тухай
 - Нүүдэлчин амьдралын мөн чанарыг таних тухай
5. Эсээний гол санааг илэрхийлэх түлхүүр өгүүлбэрийг олоорой.
- Байгаль дэлхийтэйгээ зохицон оршиход хүч тэнхээ, ухаан билгээс өөр эрхэм нь үгүй.
 - Нүүдэлчдийн сэтгэлгээний үндэс нь ийм учраас тэд хэлбэрийг ч, агуулгыг ч өөрчлөхийг төдийлөн хүсдэггүй.
 - Нүүдэлчдийн ойлголтоор, хэлбэр бол байгаль орчинтой зохицох зайлшгүй нөхцөл, агуулга бол орчлонт ертөнцөд өнө удаан оршихын үндэс.
 - Алив бүхний үнэ цэн, чанар чансааны дээд үнэлэмж бол үзэмж бус хүч тэнхээ, оюун билиг.
 - Язгуур сэтгэлгээ бол байгаль цаг агаарын эрс тэс өөрчлөлтгүй үед агуулга хэлбэрийн үл хувьслыг эрхэмлэдэг.
6. Зохиогчийн ашигласан баримт мэдээллийг шинжилж, зөв харгалзааг олоорой.

Баримтын шинжилгээ		
1	2	3
Баримтаас төрсөн зохиогчийн сэтгэгдэл	Нүүдэлчин амьдралын тухай зохиогчийн өвөрмөц бодол-эргэцүүлэл бүхий баримт	Ажиглалтаас үүдэн гарсан таамаглал бүхий баримт
Эсээнээс сонгосон баримт		
а	б	с
Тухайн үндэстэн үнэнхүү язгуур сэтгэлгээтэй байж гэмээн л ертөнц дээрх олон хэлбэрүүдийн дотроос бөмбөрцөг хэлбэрийг сонгосон байж таарна.	Нүүдэлчдийн сэтгэлгээ бол байгалийн эрхшээлээр хэрэглээгээ хязгаарлан, байгальд өөрийгөө зохицуулан өөрчлөхийг эрмэлздэг сэтгэлгээ.	Эртний монголчууд орон сууцаа бүтээхдээ гараг эрхсийн түгээмэл хэлбэр болох бөмбөрцөгөн дүрсийг сонгосон нь эдүгээгийн монгол гэр юм.

А. 1с, 2б, 3а В. 1б, 2с, 3а С. 1а, 2б, 3с Д. 1б, 2а, 3с Е. 1а, 2с, 3б

7. Монголчуудын гурван мянга гаруй жил орон сууцаа үндсээр нь өөрчлөөгүйн шалтгаан юу вэ?
- Хэрэглээний эрхшээлээр байгалийг өөртөө зохицуулан өөрчлөхийг эрмэлздэг сэтгэлгээтэй учраас
 - Байгаль цаг агаарын эрс тэс өөрчлөлтгүй үед агуулга хэлбэрийн үл хувьслыг эрхэмлэдэг учраас
 - Ямар ч догшин салхи, ширүүн бороонд унадаггүй, үерийн усанд өртдөггүй, тэсвэртэй учраас
 - Монгол гэрийн үндсэн хэлбэр төрх, хийц маяг нь нүүдэллэн хэрэглэхэд тохиромжтой учраас
 - Байгалийн эрхшээлээр хэрэглээгээ хязгаарлан, байгальд өөрийгөө зохицуулан өөрчлөх сэтгэлгээтэй учраас



8. Зохиогчийн батлан нотлох үнэлэмж илэрсэн үзэл бодол бүхий өгүүлбэрийг олоорой.
- Бөх батаас гадна зохицлыг илүү бодсон нь илт.
 - Нүүдэлчин монголчууд бол язгуур сэтгэлгээт үндэстэн.
 - Хүн төрөлхтний үлэг оршил нь нүүдэл.
 - Өвөг оршил нь язгуур сэтгэлгээг бий болгоно.
 - Сархинаг тоонот гэр ямар ч ширүүн бороонд унадаггүй.
9. Эсээний нэг нь нөгөөдөө багтсан (агуулах → агуулагдах) харьцааг илэрхийлж буй үг хэллэг аль вэ?
- язгуур сэтгэлгээ → суурин сэтгэлгээ
 - үлэг оршил → өвөг оршил
 - хатгуур тооно → сархинаг тооно
 - одот ертөнц → орчлон ертөнц
 - бөмбөрцөг хэлбэр → олон хэлбэр
10. “Нүүдэлчдийн ойлголтоор, хэлбэр бол байгаль орчинтой зохицох зайлшгүй нөхцөл, агуулга бол орчлонт ертөнцөд өнө удаан оршихын үндэс.” өгүүлбэрт зохиогчийн ашигласан найруулгын уран маягийг оновчтой тайлбарласан нь аль вэ?
- Агуулга, хэлбэр хоёрын эсрэг болохыг сөргүүлэн тайлбарласан
 - Агуулга, хэлбэр хоёрын төстэй болохыг ижилсүүлэн тайлбарласан
 - Агуулга, хэлбэр хоёрын адил тэгш эрхтэйг зэрэгцүүлэн тайлбарласан
 - Агуулга нь хэлбэрээс давуу болохыг ахиулан тайлбарласан
 - Агуулга, хэлбэрийн ижил төстэйг сөөлжүүлэн тайлбарласан
11. “Оршин байх **хэлбэрүүдийн** дотроос хамгийн бөх бат, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр.” өгүүлбэрийн тодруулсан “хэлбэрүүдийн” гэсэн үгийг оновчтой салаалан хувиргасан нь аль вэ?
- Оршин байх үзэгдлүүдийн дотроос хамгийн бат бөх, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр.
 - Оршин байх байдлын дотроос хамгийн бөх бат, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр.
 - Оршин байх төлөвүүдийн дотроос хамгийн бөх бат, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр.
 - Оршин байх нөхцөлийн дотроос хамгийн бөх бат, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр.
 - Оршин байх биетүүдийн дотроос хамгийн бат бөх, төгс төгөлдөр нь бөмбөрцөг хэлбэр.
12. “Монгол гэрийн үндсэн **хэлбэр төрх**, хийц маяг нь өөрчлөгдөлгүй манай үед хүрч ирсний гол шалтгааныг зөвхөн нүүдэллэн хэрэглэхэд тохиромжтой байснаар тайлбарлавал өрөөсгөл болно.” өгүүлбэрийн “хэлбэр төрх” гэсэн үг аль үгтэй холбогдож, ямар гишүүн болох вэ?
- “өөрчлөгдөлгүй” үгтэй холбогдож, өгүүлэгдэхүүн гишүүн
 - “өөрчлөгдөлгүй” үгтэй холбогдож, өгүүлэхүүн гишүүн
 - “хийц маяг” үгтэй холбогдож, тодотгол гишүүн
 - “хийц маяг” үгтэй холбогдож, өгүүлэгдэхүүн гишүүн
 - “хүрч ирсний” үгтэй холбогдож, өгүүлэхүүн гишүүн
13. Олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэрийг олж сонгоорой.
- Ерөөс язгуур сэтгэлгээ бол байгаль цаг агаарын эрс тэс өөрчлөлтгүй үед агуулга хэлбэрийн үл хувьслыг эрхэмлэдэг.
 - Эртний монголчууд орон сууцаа бүтээхдээ гараг эрхсийн түгээмэл хэлбэр болох бөмбөрцөгөн дүрсийг сонгосон.
 - Байгаль дэлхийтэйгээ зохицон оршиход хүч тэнхээ, ухаан билгээс өөр эрхэм нь үгүй.
 - Нүүдэлчдийн ойлголтоор, хэлбэр бол байгаль орчинтой зохицох зайлшгүй нөхцөл, агуулга бол орчлонт ертөнцөд өнө удаан оршихын үндэс.
 - Нүүдэлчдийн сэтгэлгээ бол байгалийн эрхшээлээр хэрэглээгээ хязгаарлан, байгальд өөрийгөө зохицуулан өөрчлөхийг эрмэлздэг сэтгэлгээ.
14. “Хүн төрөлхтний **үлэг** оршил нь нүүдэл.” өгүүлбэрийн “үлэг” гэсэн үгээр зохиогч цаг хугацааны ямар утга илэрхийлэхийг зорьсон бэ?
- өнгөрсөн цаг
 - өнөө цаг
 - өмнөх цаг
 - эрин цаг
 - балар цаг
15. Эсээнд байгаа “сэтгэлгээ” гэсэн үгтэй нэг гаралтай үгийг олоорой.
- сэдэргэнэ
 - сэдгэр
 - сэдэл
 - сэтэрхий
 - сэдэс
16. Үйлээс нэр үг бүтээх -л дагавартай бүлэг үг нь аль вэ?
- зохицол, сэтгэл, оршил, байгаль
 - түгээмэл, эрхшээл, үзэгдэл, нүүдэл
 - оршил, зохицол, ургамал, эрхшээл
 - үзэгдэл, оршил, эрхшээл, зохицол
 - нөхцөл, түгээмэл, нүүдэл, үзэгдэл
17. Үгийн бүтцийн зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирох үгийг олоорой.
- харилцаа, үндэстэн, сэтгэл, амьтан, ...
- тохиромж
 - хөдөлгөөн
 - ургамал
 - маргаан
 - агуулга



18. Үйлийн хам холбох нөхцөлөөр хэлбэржсэн холбоо үгсийг олоорой.
 А. хэрэглээгээ хязгаарлан, зохицон орших
 В. ойртон шовойх, догшин салхи
 С. бөмбөрцгөн дүрс, зохицуулан өөрчлөх
 Д. үргэлжийн хөдөлгөөн, орчлон ертөнц
 Е. төдийлөн хүсэх, орон сууц
19. Доорх үгсийн бүтээврийн нийлц дэх дүрмийн зөв бодомжийг олоорой.
- | | | | | | | | | | |
|---------|---|-----|---|------------|--------|---|-----|---|-----------|
| хийсвэр | + | ээс | = | хийсвэрээс | хэлбэр | + | ийг | = | хэлбэрийг |
|---------|---|-----|---|------------|--------|---|-----|---|-----------|
- А. Үгийн дунд ялгах үүрэгтэй орсон эгшгийг гээхгүй бичнэ.
 В. Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшгийг гээхгүй.
 С. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэхгүй.
 Д. Дараалсан хоёр заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшгийг гээхгүй.
 Е. Зарим үгийн балархай эгшгийг гээхэд үгийн үндэс ихээхэн өөрчлөгдөхөөр болбол балархай эгшгийг гээхгүй.
20. “Гийгүүлэгчээр төгссөн үгэнд гийгүүлэгч залгахад үгийн эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ.” дүрэмд хамаарах үг аль нь вэ?
 А. зохицон
 В. ойртон
 С. суурин
 Д. орчлон
 Е. гурван
21. Зөөлний тэмдэг и болсон үг аль нь вэ?
 А. оршихуй
 В. харилцаа
 С. нүүдэлчин
 Д. салхи
 Е. билиг

Уран зохиол:

- Л.Түдэвийн “Оройгүй сүм” романы хэсгийг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

...Хоёр давхар алтадсан оройтой, ногоон паалантай туйпуугаар уран гоё барьсан, жижигхэн дуган дотор төвлөрүүлэн босгосон, давтмал мөнгөн чимэгтэй, шар торгон өнгөлөгтэй суваргын өмнө хэдэн зуун зул ярайж байлаа.

Суваргын эгц өмнөх сэнтий мэт ширээнээ нэг алт, хоёр мөнгө, нэг чулуун цөгцтэй том зул, гуулин цөгцтэй жижиг зулнууд, тэрнээс цааш мөргөлчдийн тавьсан тоо томшгүй олон зул байна. Гэлэн Чоймчиг тус бүр нь таван чох* зоосны үнэтэй жижигхэн зул гурвыг хажуугийн мухлагаас худалдан авч ирээд, нэгийг гэгцэл Санжид өгч, нөгөө хоёрыг өөрөө асааж суваргын өмнө өргөв. -За одоо санаа амарлаа! гэж Чоймчиг гэлэн шавийнхаа чихэнд шивгэнээд гарахаар үүд зүглэв. “Багш ламтан баруун хийдэд Далай лам зургаадугаарын шарилд зул өргөхдөө “За одоо санаа амарлаа” гэж байсан. Энд бас л тэгж хэлэх юм. Санаа нь нэг л юманд зовоод яваа юм уу даа? Юунд зовдог билээ? Төрөл садан ч үгүй, эр ганц хүн шүү дээ. Эсвэл ер нь тэгж хэлдэг заншилтай юм уу?” гэж гэгцэл бодов. Багшийгаа огт барцадгүй хүн гэж тэр итгэдэг юм...

чих* - хятад зоос

22. Зохиолын хэсгээс шашны хам сэдвийг тодорхойлох үг хэллэгийг олж сонгоорой.
 А. хажуугийн мухлаг, эр ганц хүн, барцадгүй хүн, шарилд зул өргөх
 В. гэгцэл Санж, гэлэн Чоймчиг, Далай лам, сэнтий мэт ширээ
 С. шар торгон өнгөлөгтэй суварга, чулуун цөгцтэй том зул, Далай лам
 Д. алтадсан орой, ногоон паалантай туйпуу, давтмал мөнгөн чимэг
 Е. нэг алт, хоёр мөнгө, гуулин цөгцтэй жижиг зул, төрөл садан
23. Зохиолын тодруулсан хэсэгт үндэсний бахархалт сэтгэлгээний ямар утга илэрч байна вэ?
 А. Хүний гараар бүтээсэн уран барилгын хийцийг нарийн дүрслэх утга
 В. Бурхан шашны сүм суваргын үзэмж төрхийг илэрхийлэх утга
 С. Дархан хүний ур ухаанаа шингээн босгосон бүтээлийг магтах утга
 Д. Төрөл бүрийн эд зүйлийг ашиглаж байсан тухай тайлбарлах утга
 Е. Сүм дуганын чанар чансаа, өнгө үзэмжийг товойлгон дүрслэх утга
24. Зохиолын хэсэгт хэтрүүлэн ихэсгэсэн уран дүрслэл аль нь вэ?
 А. эр ганц хүн
 В. сэнтий мэт ширээ
 С. ногоон паалантай туйпуу
 Д. огт барцадгүй хүн
 Е. хэдэн зуун зул
25. Санжийн дотоод ярианаас дүрийн бодлын өсөлтийг оновчтой илэрхийлсэн бичиглэлийг олоорой.

А.	багшийн үг	→	нэг юм	→	төрөл садан	→	заншил
В.	хэлснийг санах	→	өөрөөсөө асуух	→	бодох	→	итгэх
С.	зул	→	чих	→	эр	→	итгэл
Д.	санаа амрах	→	дахин хэлэх	→	санаа зовох	→	бодох
Е.	асаах	→	өргөх	→	шивгэнэх	→	гарах



26. Чоймчиг гэлэнгийн “За одоо санаа амарлаа!” гэсэн үгээр дотоод орчны ямар өнгө аяс илэрч байна вэ?
 - A. Сэтгэл шулуудаж, яарч догдолсон өнгө аяс
 - B. Шавьдаа бүхнээ даатгахаар шийдсэн өнгө аяс
 - C. Дутуу дулимагтаа сэтгэл зовсон өнгө аяс
 - D. Зорьсон ажилдаа сэтгэл ханасан өнгө аяс
 - E. Гэлэнгийн үнэнхүү сүсэглэсэн өнгө аяс
27. Багшийн хэлсэн үг, хийсэн үйлдэл Санжийн дүрд хэрхэн нөлөөлж байна вэ?
 - A. Далай ламд зул өргөх ёс горимд зөв суралцахад нөлөөлсөн.
 - B. Багш хүн шавьдаа хэрхэн ханддагийг ойлгоход нөлөөлсөн.
 - C. Багшийн тухай тунгаан эргэцүүлж, дүгнэлт гаргахад нөлөөлсөн.
 - D. Бусдын төлөө санаа зовних сэтгэлтэй болоход нөлөөлсөн.
 - E. “За одоо санаа амарлаа!” гэх үгийн утгыг ухахад нөлөөлсөн.
28. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж уран зохиолын тодорхойлолтыг гүйцээнэ үү.
... дүр гэдэг нь тухайн нийгмийн хүмүүсийн зан төрх, ёс суртахууны шинж байдлыг хадгалсан дүрийг хэлнэ.
 - A. бодгаль
 - B. нийтлэг
 - C. туслах
 - D. болзолт
 - E. сөрөг
29. “Монголын нууц товчоо”-д Гурван Мэргэдийн эздийн тухай Жамухын өгүүлсэн:
“Давирах гөлмийн чимээг
Дайны хэнгэргийн дуу гэж
Ташааран дутаагч Тогтоа
Дайд Буур Хээрт
Ташаалдан суугаа буй за” хэсгийн хэл найруулга, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг оновчтой тодорхойлсон нь аль вэ?
 - A. Дүрийн андуу эндүүтэй, аймхай хулчгар зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
 - B. Дүрийн хөнгөн хийсвэр, буурь суурьгүй зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
 - C. Дүрийн яаруу сандруу, ахар бодолтой зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
 - D. Дүрийн ихэмсэг бардам, ойворгон хөөрүү зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
 - E. Дүрийн байлдаанч чадваргүй, арчаагүй дорой зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
30. “Монголын нууц товчоо”-ы Тэмүүжин, Жамухтай нөхөрлөхдөө хэлсэн:
Ахас дээдсийн үгийг сонсвол,
Аливаа хүн харилцан
Анд нөхөр бололцвол
Амь биедээ арч болж
Аль алиндаа түшиг болж
Амраглан ханилах ёстой” хэсэгт шүлгийн ямар холбоц байна вэ?
 - A. зэрэгцэх холбоц
 - B. тэгш холбоц
 - C. сөөлжүүлэх холбоц
 - D. хаших холбоц
 - E. салаавчлах холбоц

Үндэсний бичиг:

- Эхийг үншиж ойлгоод, асуулт даалгаврыг гүйцэтгээрэй.

[illegible]

31.  A. Сорхон Шард хөндлөнгийн муу үг аюултайг айлдсан.
B. Шадар нөхдөдөө хөвсөргөн муу үг аюултайг айлдсан.
C. Чулуун, Чимбай хоёрт халтай муу үг аюултайг айлдсан.
D. Олон аймгуудад хажуугийн муу үг аюултайг айлдсан.
E. Хөвгүүндээ хөндлөнгийн муу үг аюултайг айлдсан.



32.

ایک کو حق
پہنچتا ہے جس کا
مصرحہ میں ہے
ہو۔

ہنرمند کو
لڑائی میں
ہوئے ہیں

- A. Эвтэй найртай, энх амгалан байх
B. Үймээн самуун, орчил тэмцэлтэй байх
C. Сонор сэрэмжтэй, анхаарал болгоомжтой байх
D. Үнэнч үгтэй, шударга үйлстэй байх
E. Эв түнжингүй, хагарал бутралтай байх

33.

ہمسکایہ ہمسکایہ
ہمسکایہ ہمسکایہ
ہمسکایہ ہمسکایہ
ہمسکایہ ..

- A. یتوق
B. لڑائی
C. رہنمائی
D. یتوق
E. رہنمائی

34.

یتوق
موجودہ
مصرحہ میں
ہمسکایہ
ہو۔

- A. رہنمائی
B. رہنمائی
C. رہنمائی
D. رہنمائی
E. رہنمائی

35.

یتوق
ہمسکایہ
مصرحہ میں
ہمسکایہ
ہو۔

- A. رہنمائی
B. رہنمائی
C. رہنمائی
D. رہنمائی
E. رہنمائی

36.

مصرحہ میں ہے
حق و شہادت میں
ہو۔

Үүнийх нь
ачаар Чингис
хааныг үнэнч
үгтэй,
шударга
нөхөд тойрон
хүрээлж
чадсан билээ.

- A. یتوق و لڑائی میں
ہمسکایہ میں
ہمسکایہ ..
B. یتوق و لڑائی میں
ہمسکایہ میں
ہمسکایہ ..
C. یتوق و لڑائی میں
ہمسکایہ میں
ہمسکایہ ..
D. یتوق و لڑائی میں
ہمسکایہ میں
ہمسکایہ ..
E. یتوق و لڑائی میں
ہمسکایہ میں
ہمسکایہ ..

37.

ہمسکایہ
مصرحہ میں
ہمسکایہ ..

1. یتوق

2. رہنمائی

3. رہنمائی

- a. засах, тохинуулах
b. зөвшөөрөх, батлах
c. орших, эргэлдэх

A. 1a,2c,3b

B. 1c,2a,3b

C. 1c,2b,3a

D. 1a,2b,3c

E. 1b,2a,3c



- | | | |
|-----|--|---|
| 38. | <p>«Хүн бүхэн нь эхнэрийнхээгээ хайрладаг» гэж үгүйсгэх үгүйсгэлтэй үг хэргийг олж олох.</p> | <p>A. үгүйсгэх</p> <p>B. үгүйсгэх</p> <p>C. үгүйсгэх</p> <p>D. үгүйсгэх</p> <p>E. үгүйсгэх</p> |
| 39. | <p>«Хүн бүхэн нь эхнэрийнхээгээ хайрладаг» гэж үгүйсгэх үгүйсгэлтэй үг хэргийг олж олох.</p> | <p>a. шар - хор шар, уур омог</p> <p>b. шар - агталсан эр үхэр</p> <p>c. шар - халдварт өвчин</p> <p>A. a1,b1,c2</p> <p>B. a2,b1,c1</p> <p>C. a1,b2,c1</p> <p>D. a2,b2,c1</p> <p>E. a1, b2,c2</p> |
| 40. | <p>«Хүн бүхэн нь эхнэрийнхээгээ хайрладаг» гэж үгүйсгэх үгүйсгэлтэй үг хэргийг олж олох.</p> | <p>A. үгүйсгэх</p> <p>B. үгүйсгэх</p> <p>C. үгүйсгэх</p> <p>D. үгүйсгэх</p> <p>E. үгүйсгэх</p> |



Хоёрдугаар хэсэг. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

- Энэ хэсэг нь 4 даалгавар, нийт 20 оноотой.
- Сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, тохирох хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Хэлц өгүүлбэрийн гэ-, хэмээ- холбох үгийг илрэх утгатай нь харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дүгээрт байгаа нэр томьёо давхцаж болно.)

Хэлц өгүүлбэр		Холбох үг	Илрэх утга
• Хэлсэн үг нь цэцэн гэж аргагүй - Явсан мөр нь шулуун гэж аргагүй • Татах гээд түлхэгдэх - Чичлэх гээд алдах. • Хилэгнэх гэгч урины нэр - Харилхана гэгч атааны нэр.	• Өгнө гэхэд өрвөс хийнэ - Авна гэхэд арвас хийнэ. • Харъя гэвэл нүд муу - Хазъя гэвэл шүдгүй - Хамар гэвэл харанхуй нүх.	a. гэж b. гээд c. гэгч d. гэхэд e. гэвэл	1. шалтгааны утга 2. зорилгын утга 3. болзлын утга 4. тодосгогчийн утга

2.2. Ятган итгүүлж бичихэд ашиглах дүрслэлийн жишээг нэр томьёотой нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2 дугаарт байгаа нэр томьёо давхцаж болно.)

- | | |
|-----------------|----------------------|
| a. алд бие | |
| b. хатан зориг | 1. Ерийн тодотгол |
| c. хөх хомоол | 2. Зүйрлэлт чимэг үг |
| d. мөнгөн сар | |
| e. дулаан хавар | |

2.3. Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы тодруулсан хэсгийг уран дүрслэлтэй нь тохируулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дүгээрт байгаа нэр томьёо давхцаж болно.)

a. Энэ майханд орсон зовлон надад хамаагүй гэсэн юм шиг Тамирын гол жигдхэн шуугьж, дорно зүгээс улам тодорч байгаа үүрийн гэгээ нойрссон ертөнцөд шинэ өдөр мэндэлснийг баяртай тунхаглана. b. Гайхамшигт гэгээний ид шидэд биширсэн Долгор тэр мундаг чулууны хойгуур гарахдаа гурван халуун амиа даатган хэдэн удаа сунаж мөргөжээ. c. “Долоо хоногийн өлийг дуулж байгаад давдаг хүн, далан өртөө газрыг дөрөөн дээрээ туулдаг эр” гэх зэргээр Төмөрийг шагшин магтжээ. d. – Аав аа, та тэр чулууг орхимжоороо үүрээд явж чадах уу? – Аав нь төрийн хар хүн болохоор орхимж байхгүй. e. Эрдэнэ майхны үүдэнд дуугүй зогсож байснаа аргамж, чөдрөө майхны хаяа руу шидэж “хулгай аваад явчихжээ” гэж хэлэв.	1. тойруулал 2. ихэсгэл 3. хүншүүлэл 4. төлөөлөл
---	---

2.4. Холбоо үгийг уншаад бичлэг ижил, утга өөр бүтээврийг нэр томьёотой нь харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дүгээрт байгаа нэр томьёо давхцаж болно.)

- | | | | | | |
|-------------|-------------|-------------|-------------|-------------|--|
| A. | B. | C. | D. | E. | |
| ᠨᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ | ᠨᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ | ᠨᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ | ᠨᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ | ᠨᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ | 1. Үйлээс нэр үг бүтээх -аа ⁴ дагавар |
| | | | | | 2. Бусдаар үйлдүүлэх хэвийн -га ⁴ дагавар |
| | | | | | 3. Үйлээс нэр үг бүтээх -гаа ⁴ дагавар |
| | | | | | 4. Тодотгон холбох -аа ⁴ нөхцөл |

